

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор  
Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112  
Цахим хаяг: [Khentii@audit.gov.mn](mailto:Khentii@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 70562147  
Цахим хаяг: [otuya\\_099@yahoo.com](mailto:otuya_099@yahoo.com)

Аудитор: Т.Алтанзул  
Утас: 70562147  
Цахим хаяг: [altanzult@audit.gov.mn](mailto:altanzult@audit.gov.mn)

ТАБ-ын хаяг  
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн сум  
3-р баг АЗДТГ-ын байр  
Цахим хуудас: [Khentii@audit.gov.mn](mailto:Khentii@audit.gov.mn)

2018 оны 2 дугаар сар

## Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

**Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/180/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Т.Алтанзул хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 31-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

**Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн эрхэм зорилго нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг аймаг орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлж, хэрэгчдийг албан ёсны төвлөрсөн мэдээллээр чанартай хангах явдал юм.

Монгол улсын Статистикийн тухай хуулийн 12-р зүйлийн 12.3-т Үндэсний статистикийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 1/албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн төвлөрсөн удирдлагаар хангах, боловсронгуй болгох арга хэмжээ авах;
- 2/албан ёсны статистикийн үзүүлэлтийг тооцох, тооллого, судалгаа явуулах талаар ойрын зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах;
- 3/албан ёсны статистикийн мэдээлэл, судалгаа, тооллогын үзүүлэлт, аргачлал, зааварыг батлах, мэдээлэх хугацааг тогтоох;
- 4/захиргааны статистикийн мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэлтэй давхардуулахгүй байх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хянах, захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, зөвшөөрөх, мэдээллийн хамралт, үнэн зөв байдалд үнэлэлт өгөх;
- 5/хүн ам, нийгэм, эдийн засгийн холбогдолтой асуудлаар улсын тооллого, нэг удаагийн бүртгэл, тодорхой сэдвээр түүвэр болон иж бүрэн судалгаа явуулах талаар албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, мэдээлэгчид удирдамж, чиглэл өгч, биелэлтэд нь хяналт тавих;
- 6/албан ёсны статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн бусад албан газраас тогтоосон хугацаанд авах;
- 7/статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж мөрдүүлэх;
- 8/статистикийн мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тараах, статистикийн мэдээллийн ил тод байдлыг хангах;
- 9/албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд статистикийн мэдээлэгчээс авах;
- 10/төрийн байгууллагуудыг статистикийн мэдээллээр үнэ төлбөргүй хангах зэрэг үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаас олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

115

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 6 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

116

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 74.56 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 73.48 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1.08 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусгана.

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан 6.1.6 Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгаан тайлбарын хамт, 6.1.5 Төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт, 6.1.4 Баталгаажсан санхүүгийн тайлан /хагас жил/, /бүтэн жилээр/ мэдээллийг байршуулаагүй байна. Нийт 42 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 6 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгасан, цалингийн зардлыг холбогдох заавар журмын дагуу бүртгээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Цалингийн зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад 59.4 сая төгрөгийн олговол зохих цалинг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.6 болон үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цалингийн зардлыг тооцохдоо тооцооны дансаар дамжуулан бүртгэж, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

2. 2016 оны санхүүгийн тайланд НДШ-ийн өглөг дансанд 0.59 сая, татаас санхүүжилтийн авлага дансанд 0.59 сая төгрөгийг тус тус бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19 дүгээр зүйлийн 19.1.5-д “эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалт болон оршин байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Авлага дансны 0.59 сая төгрөг, өглөг дансны 0.59 сая төгрөгөөр тус тус бууруулахаар залруулгын бичилт хийх

Аудитаар материаллаг зөрчил илрээгүй байна.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Материаллаг бус 59.4 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулах шаардлагагүй гэж үзлээ.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 59.4 сая төгрөгийн 1 алдаа, зөрчил илэрсэн ба дээрхи алдаа зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

**Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**

**Зөрчилгүй санал дүгнэлт**


Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн


Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 6 хуудас, аудитын гэрчилгээ 2 хуудас менежментийн захидал 4 хуудас байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.


**Аудитын тайланг**

**Хянасан:**

Дарга, Тэргүүлэх аудитор  / Ч.Эрдэнэбаатар/

Аудитын менежер  / Д.Оюунтуяа/

**Бэлтгэсэн:**

Аудитор  / Т.Алтанзул/



**Огноо: 2018.02.13**





## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2018.02.14 № 06/04  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хэнтий аймаг дахь  
Төрийн аудитын газар

13

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Цалингийн зардлын талаар  
.....2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар  
.....3

2018 оны 02 дугаар 13 сар

## Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга Т.Өлзийсүрэн, нягтлан бодогч А.Мөнх-Уянга нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

Цалингийн зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад нийт 59.4 сая төгрөгийн олговол зохих цалингийн бүртгэлийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 3.6 дахь заалт болон үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Цалинг буруу тооцож олгох Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнах

АГ-ын зөвлөмж

Цалингийн зардлын бүртгэлийг тооцооны дансаар дамжуулан хөтлөж, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 2: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** **Тэргүүлэх ач холбогдол №2**

**АГ-ын ажиглалт**

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан дараах мэдээллүүдийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнд:  
 6.1.6 Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгаан тайлбарын хамт  
 6.1.5 Төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт  
 6.1.4 Санхүүгийн тайлан /хагас жил/, /бүтэн жилээр/ баталгаажуулаагүй тайлан оруулсан.

**АГ-ын зөвлөмж**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчим болон, 6 дугаар зүйлд заасан заалтуудыг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөх

**Эрсдэлүүд**

Хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**


**ХЯНАСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Т.АЛТАНЗУЛ

**Огноо: 2018.02.13**